

ГАН ХИЙЦ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улаанбаатар хот

2025.04.25

Ган хийц ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 11:40 минут компанийн ТУЗ-ийн даргын өрөөнд хийв.

Хуралд: Хувьцаа эзэмшигч М.Даваасүрэн, Л.Чинбат, Лувсандорж нар оролцлоо.

Хуралд тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 72,22% буюу 175112 ширхэг хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирсэн тул Компанийн тухай хуулийн дагуу хурлын ирц бүрдсэн гэж үзээд хурлыг эхлэв.

Хурлын даргаар Хувьцаа эзэмшигч М.Даваасүрэн, нарийн бичгийн даргаар О.Ууганцэцэг

Хурлын дарга хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дотоод журмыг тус тус танилцуулж, батлуулав. Хурлыг 11:40 минут эхэлж, 12:30 цагт дуусгахыг санал оруулж батлууллав.

Бүх хэлэлцэх асуудлаа танилцуулж дуусаад санал хүсэлтээ хэлэх санал оруулж байна. Хуралд оролцсон бүх гишүүд 100 хувь саналаар зөвшөөрөв.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг танилцуулах
2. Ногдол ашгийн талаар ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан
4. ТУЗ-ийн 2025 оны зардлын төсөв, Компанийн 2025 оны захиргаа, үйлчилгээний зардлын төсвийг батлах
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

Хэлэлцсэн нь:

Хэлэлцэх асуудлын дараагалын дагуу ТУЗ-ийн хийсэн ажлын тайлан болон компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн танилцуулав. Тайлан дараах чиглэлээр тайланг танилцуулав.

Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг танилцуулах
Ногдол ашгийн талаар ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан
ТУЗ-ийн 2025 оны зардлын төсөв, Компанийн 2025 оны захиргаа, үйлчилгээний зардлын төсвийг батлах

2024 онд Ган хийц ХК-ийн Төмөр хийцийн үйлдвэр төслийн борлуулалтын орлого 190 сая төгрөг, төмөр хийцийн үйлдвэрлэлийн борлуулалтын орлого 820 сая төгрөг, зургийн ажил 12,6 сая төгрөг, бусад борлуулалтын орлого 38,5 сая төгрөг, түрээсийн орлого 117,4 сая төгрөг болсон бөгөөд нийт 2,2 тэрбум төгрөгийн борлуулалттай ажигласан байна.

2023, 2024 оны борлуулалтын орлогыг харьцуулсан байдлаар харуулхад 2024 онд төслийн борлуулалтын орлого багассан байгаа нь харагдаж байна.

Удирдлага болон үйл ажиллагааны зардал 1,169,836.440 төгрөгийн зардал гарсан байна. 2024 онд татвар, нийгмийн даатгалын зардлыг харуулсан. Та бүхэн танилцаарай. Санхүүгийн дүгнэлтийг харууллаа.

1. Тайлант хугацаанд борлуулалтын орлого гүйцэтгэл хангаагүй боловч борлуулсан бүтээгдэхүүний өртгийг төлөвлөсөн түвшнээс 28%-иар, өмнөх онтой харьцуулахад 42%-иар тус тус бууруулж ажигласан.
2. Тайлант хугацаанд удирдлагын зардлыг төлөвлөсөн түвшнээс 17,8%-иар, өмнөх онтой харьцуулахад 4%-иар тус тус бууруулж ажилласан.
3. Нийт авлага 2023 онтой харьцуулахад 59%-иар буурсан. БНХАУ-ын түүхий эд захиалгын 1,239.1 сая төгрөгийн авлагыг данснаас хасч найдваргүй авлагын нөөц байгуулсан нь авлагын бууралтанд хамгийн ихээр нөлөөлж байна.
4. Нийт өглөг 2023 онтой харьцуулахад 0,8%-иар өссөн байна. Тайлант онд банкны богино хугацаат зээл, зээлийн хүүгийн өглөгт 823,6 сая, татварын өглөгт 145,1 сая, НДШ-ийн өглөгт 240,2 сая, харилцагчид төлөх өглөгт 145,6 сая, нийт 1,354.5 сая төгрөгийг өр төлбөр барагдуулахад төлсөн

Хоёрдугаар асуудал: Ногдол ашгийн талаар ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 02 дугаартай тогтоолоор 2024 оны санхүүгийн тайлан **-6,584,641.84** төгрөгийн алдагдалтай гарсан тул 2024 оны үйл ажиллагаанд ногдол ашиг тарвахгүйгээр шийдвэрлэсэн.

Гуравдугаар асуудал: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан

2024 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, дэргэдэх хороод дараах ажлуудыг зохион байгуулсан.

- Ган хийц ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хууль, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиглах журмын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.
- Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй бөгөөд ердийн гишүүд 6, хараат бус гишүүд 3-тай ажиллаж байна.
- Аудитын хороо, нэр дэвдүүлэх хороо, цалин урамшууллын хороо гэсэн 3 хороотой үйл ажиллагаа явуулж байна.
- Тухай бүр шаардлагатай хурлуудыг зарлан хуралдуулж, холбогдох шийдвэрүүдийг гарган ажигласан.
- Хөрөнгийн биржийн цахим системд мэдээллийг тухай бүр мэдээлэн ажиглаж байна.

- Хагас жил, жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайланг цаг хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлэн ажигласан.
- Тус хороо нь 2024 онд хийх ажлын төлөвлөгөөг гаргаж, төлөвлөгөөний дагуу хийсэн ажлын тайланг танилцуулсан.
- Тайлант онд тухай бүр компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн бичилттэй танилцаж, нягтлан бодох бүртгэлийн бичилтүүдийн талаар зөвлөгөө өгсөн.
- Компанийн үндсэн хөрөнгийн элэгдүүлэлт бүртгэл хөтлөлттэй танилцаж, Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нарт санал солилцож зөвлөгөө өгч ажиллалаа.
- Компанийн нягтлан бодох бүртгэл аккुरиал сууриар бүтгэгддэгийг анхаарч ажил үйлчилгээг үзүүлсэн тухай бүрийд нягтлан бодох бүртгэлд бичилт хийхийг зөвлөв.
- Өр авлагыг бууруулах талаар эрчимтэй хөөцөлдөж барагдуулахыг зөвлөсөн.
- Компанийн санхүүгийн бодлогыг баримт бичигтэй танилцсан. Санхүүгийн бодлогын баримт бичиг нь хуучирсан тул шинэчлэх шаардлагатай. Компанийн НББ-ийн бичиг баримтанд нэмж оруулах, засч сайжруулах санал төслөө бичиж өгсөн.
- Харилцан хамгаарал бүхий компаниудтай хийсэн тооцоог баталгаажуулах, нягтлан бодох бүртгэлд бичилт хийхийг анхааруулсан.
- Ган хийц ХК-ийн очиж ажиллаж, ерөнхий нягтлан бодогчтой сар бүр утсаар холбогдож, НББ талаар санал солилцож, зөвлөгөө өгч ажилласан.
- Ногдол ашгийн бодлогыг боловсруулан батлуулав.
- 2021, 2022 онууд нэгж хувьцаанд 100 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бөгөөд үүнийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй 2024 онд гэрээг хийж, ногдол ашгийг шилжүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан.
- 2021 оны 117 хувьцаа эзэмшигчийн 17,284 ширхэг хувьцаанд 1,614,680 төгрөгийн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан тараасан.
- 2022 оны 119 хувьцаа эзэмшигчийн 17,284 ширхэг хувьцаанд 1,624,625 төгрөгийн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан тараасан.
- Санхүүгийн зохицуулах хорооны ногдол ашгийн бүртгэлийн мэдээлэлд 2021, 2022, 2023 оны ногдол ашгийг бүртгэлийг оруулсан.
- 2024.04.05-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дараах журмыг шинэчлэн батлуулав. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам
 - ☐ Аудитын хорооны журам
 - ☐ Нэр дэвшүүлэх хорооны журам
 - ☐ Цалин урамшууллын хорооны журам

- ☐ ТУЗ-ийн нарийн бичгийн ажиллах журам
- ☐ Ногдол ашгийн бодлого
- ☐ Мэдээллийн ил тод байдлын журам
- ☐ Ёс зүйн дүрэм

➤ Байгууллагын вэбсайтад ил тод нээлттэй байршуулсан.

2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөр тасалбар болгон хувьцаа эзэмшигчийн жагсаалтыг өгсөн бөгөөд манай компанийн хувьцаа нь 30 брокерын компаниудад 242464 ширхэг хувьцаа байршдаг бөгөөд хамгийн их хувьцаа нь Тулгатчандмань баян ҮЦК, Би ди сек ҮЦК брокерийн компаниудад байршсан байна.

Дөрөвдүгээр асуудал: ТУЗ-ийн 2025 оны зардлын төсөв, Компанийн 2025 оны захиргаа, үйлчилгээний зардлын төсвийг батлах

2025 оны 4 дүгээр сарын 14-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд Гүйцэтгэх захиралын танилцуулсан ТУЗ-ийн 2025 оны зардлын төсөв, Компанийн 2025 оны захиргаа, үйлчилгээний зардлын төсвийн та бүхэнд танилцуулж байна. Дараах байдлаар төлөвлөсөн байна.

2025 онд 450 тонн төмөр хийц үйлдвэрлэж, Борлуулалтын орлогыг 4,091,190,180 төгрөг, Борлуулсан бүтээгдэхүүний орлого 2,179,872,910 төгрөг, ТУЗ-ийн зардал 149,296,080 төгрөг, Захиргаа удирдлагын зардал 897,770,780 төгрөг **Хаасралтаар холбогдох зардлын дэлгэрэнгүйг орууллаа.**

Тавдугаар асуудал: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдий сонгох

Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 6 нь ердийн, 3 нь энэ дүрмийн 7.25-д заасан шалгуурыг хангасан хараат бус гишүүн байна.

ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 2 жил байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуулснаар бүрэн эрх үргэлжилнэ.

Компанийн дүрмийн 7.25. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь дараах шалгуурыг хангасан этгээд байна:

7.25.1. дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэггүй;

7.25.2. өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанид болон компани оролцогч нь болж байгаа нэгдлийн бусад оролцогч компанид эрх бүхий албан тушаал хашдаггүй;

7.25.3. төрийн үйлчилгээнээс бусад төрийн алба хашдаггүй;

7.25.4. өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн өнгөрсөн жилийн нийт борлуулалтын 1 хувиас дээш хэмжээний үнийн дүн бүхий хэлцлийг компанитай хийж байгаагүй;

7.25.5. компанийн 5-аас дээш хувиаа эзэмшдэг этгээд, эсхүл компанийн эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолгүй, тэдгээрийн төрөл, садан, гэр бүлийн гишүүн биш;

7.25.6. компанийн болон түүний хараат, охин компани, компанид нэгдэлд хамаарах компанийн нэгдэлд сүүлийн 3 жилийн хугацаанд эрх бүхий албан тушаалтан болон бусад албан тушаалд ажиллаж байгаагүй;

7.25.7. компанийн өрсөлдөгч аж ахуйн нэгж болон түүнд харьяалагддаг компанийн нэгдлийн аливаа оролцогч компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд биш.

Эдгээр шаардлагадугдыг хангасан байна гэж заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр дараах хүмүүс нэр дэвшсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат гишүүнээр М.Даваасүрэн, Б.Эрдэнэбаяр, Ц.Хангай, О.Ууганцэцэг, Д.Оюунзул, С.Маргад-эрдэнэ

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр Э.Долгорсүрэн, П.Төвсанаа, Б.Гантулга

Нэр дэвшигчдийн ерөнхий мэдээллийг танилцууллаа. Та бүхэн саналын хуудсаар саналаа өгнө.

Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын дарааллын дагуу танилцууллаа. Анхаарал хандуулсан баярлалаа. Та бүхэн санал хүсэлтээ хэлнэ үү.

Чинбат: Хэлэлцсэн асуудал дээр нэмэх санал байхгүй. 2025 оны төсөв дээр нэмэх санал алга байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нарыг өмнө нь хийж байсан хүмүүс тул хэлэх саналгүй байна.

Лувсандорж: Хэлэлцэж байгаа асуудлууд бүгд тодорхой, танилцуулагдсан тул татгалзах, асууж тодруулах зүйл байхгүй байна. Дэмжиж байна.

М.Даваасүрэн: Өөр асууж тодруулах зүйл байна уу. Байхгүй бол Тооллогын комисс байгуулж, ажигд нь оруулъя. Тооллогын комиссыг дараах хүмүүсийг сонгох саналтай байна. Энд байгаа хүмүүс тооллогын комисст орж болохгүй тул менежер, нягтлан бодогч нараас сонгох саналтай байна.

Тооллогын комиссын даргаар:

Гишүүд

Т.Буяннэмэх

С.Лхамцэрэн

С.Маргад-эрдэнэ

Тооллогын комисс бол 4 асуудал дээр гурван санал хуудас хэвлэж санал хураалт явуулна.

Хурлын дарга М.Даваасүрэн: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул Тооллогын комисс ажилдаа орж саналын хуудсыг тарааж өгнө үү. Ирсэн хувьцаа эзэмшигчид саналыг хуудсыг бөглөө.

Тооллогын комиссын дарга Т.Буяннэмэх саналын дүн, тооллогын комиссын хурлын протокол, тогтоолыг уншиж танилцуулав. /протокол, тогтоолыг хавсаргав./

Шийдвэрлэсэн нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 онд хийж гүйцэтгэсэн ажлыг ХАНГАЛТТАЙ гэж дүгнэв.
2. 2025 оны ТУЗ-ийн зардлын төсвийг 149,296,080 төгрөгөөр, Компанийн үйл ажиллагааны 2025 оны төсвийг 897,770,780 төгрөгөөр батлав.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат гишүүнээр М.Даваасүрэн, Б.Эрдэнэбаяр, Ц.Хангай, О.Ууганцэцэг, Д.Оюунзул, С.Маргад-эрдэнэ нарыг сонгов.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр Э.Долгорсүрэн, П.Төвсанаа, Б.Гантулга нарыг сонгов.

Хурлын дарга М.Даваасүрэн хувьцаа эзэмшигчийн саналын дүнг үндэслэн шийдвэрлэсэн асуудалтай холбогдон гарах хурлын тогтоолын төслийг баталж, хурлаас гаргаж буй тогтоолыг уншиж танилцуулснаар хурал өндөрлөв. /тогтоолыг хавсаргав./

Хувьцаа эзэмшигчдийн хурал 2025 оны 04 дүгээр сарын 25 өдрийн 12:50 цагт өндөрлөв.

Хурлын гэмдэглэл хөтөлсөн :

Нарийн бичиг



О.Ууганцэцэг

Танилцсан:

Хурлын дарга



М.Даваасүрэн